

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 05 сарын 14 өдөр

№ 25/08

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.11 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 сарын 14-ний өдрийн хурлын санал хураалтын дүнг үндэслэн тус тус ТОГТООХ нь:

1. “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн нийт активын 5 хүртэлх хувиар холбогдох хууль, журам, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт нийцсэн хувьцаа болон бондын сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрхийг сангийн гүйцэтгэх удирдлагад олгосугай.
2. Тогтоолын 1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд дараах этгээдүүдтэй хийх хэлцлүүдийг хамруулан ойлгоно.
 - 2.1. Мандал Хуримтлал хамтын ХОС ХХК;
 - 2.2. Мандал Праявит Экүити хувийн ХОС ХХК;
 - 2.3. Мандал даатгал ХК;
 - 2.4. Тэнгэр даатгал ХК;
 - 2.5. Мандал дижитал кредит ББСБ ХХК
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сангийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Н.МОНСОП